

ЯПОН УЛС ДАХ СУРГАЛТ

2012.06.17 - 30

Сэтгэгдэл



СХД-ийн 12-р
сургуулийн захирал
Д.Наранцацралт

“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд япон улсад 14 хоногийн сургалтанд хамрагдаж япон улсын боловсролын үйл явц, сургуулийн менежменттэй танилцаж туршлага судалсан нь миний хувьд боловсролын байгууллагад олон жил ажилласны үр дүн, гавьяа байлаа.

ЖСА-ийн төслийн багийн хамт олонд баярласнаа илэрхийлье.

“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь”



Төслийн хүрээнд 22 хүний бүрэлдэхүүнтэй баг 2012 оны 06-р сарын 17-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд Япон улсын Токио хотод БШУ-ны яамны төлөөлөл, боловсролын хэлтсийн мэргэжилтэн, сургуулиудын захирал, сургалтын менежер нар сургалтанд хамрагдсан.

Сургалтын хугацаанд доорх байгууллага, сургууль, музей, түүх дурсгалын газрын үйл ажиллагаатай танилцлаа.

- ❖ Токио дах JICA-ийн төв
- ❖ Токио Гакүгэй ИС-ийн харьяа Коганэй бага сургууль
- ❖ Токио Гакүгэй ИС
- ❖ Сагамихара хотын харьяа Оонойдай бага сургууль
- ❖ Хигаши Ямато ахлах сургууль
- ❖ Токио Гакүгэй ИС-ийн харьяа ОУ дунд сургууль
- ❖ Нагано муж Чино хот
- ❖ Чино хотын харьяа Тамагава бага сургууль
- ❖ Мацүмото хотын харьяа Мэйзэн дунд сургууль
- ❖ Эртний Кайчи сургуулийн музей
- ❖ Мацүмото цамхаг
- ❖ Нагано муж боловсролын нэгдсэн төв
- ❖ Фүчюү хотын харьяа 2-р бага сургууль

Япон улсын боловсролын туршлага

1. JICA-аас бусад орнуудын боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг.

- ✓ Боловсролын орчин нөхцлийг сайжруулж байгаа байдал
- ✓ Боловсролын чанарыг дээшлүүлэх
- ✓ Боловсролын менежментийг сайжруулах үйл ажиллагаа үнэхээр гайхалтай

2. Япон улсын сургуулийн боловсрол, багшийн арга зүйг болон **боловсролын стандартын шинэчлэл 8** удаа өөрчлөн сайжруулсан байдал, сургуульд суурилсан хичээлийн судалгааны тогтолцоо хэвшсэн.

- ▶ Нээлттэй **“Хичээлийн судалгаа”**-ны өдөрлөгөөр дамжуулан сургууль дээрх хичээлийн судалгааны тогтолцооны хэрэгжилтийг сайжруулдаг.
 - Асуудлыг олон талаас нь харж чаддаг хүүхэд болгон төлөвшүүлэх, дунд ангийн боловсролын онцлогийг тусгасан хичээл боловсруулдаг.
- ▶ Хичээлд ажиглалт хийж, хүүхэд ба багшийн үйл ажиллагааг ажиглах, хичээлийн судалгааны талаар асууж мэдэх, **хэлэлцүүлэг, сайжруулсан хичээлийг үндэсний хэмжээнд** хийж хэвшсэн.
 - Эрдэмтэн, мэргэжлийн багш нар, оюутнууд, эцэг эхийг өргөн оролцуулдаг.
- ▶ Япон улсын багш нар нь сургуульд суурилсан хичээлийн судалгаа хийдэг, багаар хамтарч арга зүйгээ сайжруулах үйл ажиллагааг нь, багш бэлтгэдэг сургуультайгаа хамтран ажиллаж **муж үндэсний хэмжээнд** үйл ажиллагаа нь тогтмолжсон.
- ▶ Багшийн мэргэжил дээшлүүлэх 3, 5, 10, 15 жилийн сургалтыг багш бэлтгэх их, дээд сургууль багш нарын мэргэжил дээшлүүлэх төвөөс зохион байгуулж, багш, хүүхдийн оронд өөрийгөө тавьж дадлага ажил хийх, орчин, лабораторийг тоног төхөөрөмжөөр хангаж чадсан.

- ▶ Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоог түгээн дэлгэрүүлж, багш нарыг дэмжин хамтарч ажилладаг. /48 муж үндэсний хороотой/
- ▶ Цэцэрлэг, бага, дунд, ахлах, их дээд сургуулийн залгамж холбоо маш сайн.
- ▶ Самбар ашиглалт бол **Япон улсын өвөрмөц соёл мөн** боловч цаашид дэлхийд нийтлэг зүйл болно гэсэн зорилго тавин ажилладаг.
- ▶ **Япон улсын боловсролын түүх, соёлын тухай эртний Кайчи** сургуулийн **музей** үнэхээр гайхалтай, бичиг үсэг анх үүссэн, сургуулийн суурь тавигдсан цагаас хойш өдий хүртэлх боловсролын түүх, соёлыг бүрэн харуулж чадсан.
- ▶ Сургуулийн менежментийг боловсронгуй болгож сургуулийн зорилго, зорилтоо оновчтой тодорхой болгож чадсан туршлагаас судаллаа.

Япон улсын сургуулийн менежмент

- Сургуулийн боловсролын зорилтыг маш тодорхой, өөрийн хот, муж, сургуулийнхаа онцлогт тохируулан төлөвлөдөг. /Багш, хүүхэд, эцэг эхчүүд жилийн зорилго, зорилтоо тодорхойлдог, тухайн сургууль ямар хүн төлөвшүүлэхээ оновчтой илэрхийлдэг, зорилт бол сургуулийн заавал биелүүлэх хууль/


Өглөө хичээл
эхлэхээс өмнө 10
минут ном уншиж
хэвшсэн

•Хүүхдийн үзэл бодлыг сайн
ойлгож байж хичээлээ
төлөвлөдөг.
•АУБ, сургуулийн захиргаа,
хүүхэд, эцэг эхийг сайн судалдаг.

Хүүхэд өөрөө судалгаа
явуулдаг, зорилготой
зорилтот бүлэг болж
ажилладаг.

Сургууль багш нарын
үнэлгээг эцэг эх,
хүүхдээс авдаг.

Хүүхэд өөрийгөө
үнэлж тэр үнэлгээгээ
баталгаажуулдаг.



Сургууль, АУБ, эцэг эх, орон
нутагт оршин суугчдад хийсэн
ажлаа тайлагнадаг, захирлын
зүгээс сургуулийн үйл
ажиллагааны талаар зурагт
хуудас, бичил сонин гаргаж
тараадаг.

**ХИЧЭЭЛ ЗААХЫН ӨМНӨХ БЭЛТГЭЛ АЖИЛ ЧУХАЛ,
ТҮҮНИЙГ НЯГТЛАЖ ҮЗЭХ НЬ ХИЧЭЭЛИЙН БЭЛТГЭЛ СУДАЛГАА**

**Хичээлийн судалгаа, хичээлийн бэлтгэл ажилд маш их ач
холбогдол өгч хэвшсэн.**

**Хичээлийн судалгаа + Судалгаат хичээл заана
Судалгаат хичээл + Хичээлийн судалгаа хийнэ**

Үнэлгээний тодорхой аргатай



Багш бүр анги удирддаг системтэй

Багш бүр жилийн ажлын төлөвлөгөө гаргаж, хууль мэт мөрддөг нь амжилтын үндэс болдог.

- Хүүхдийн сурах чадварыг хөгжүүлдэг
- Хийсэн ажлыг сайн дэмждэг.

Үнэн сайхан сэтгэлтэй, бүтээлч сэтгэлгээтэй, сайн бодож төлөвлөдөг, бие сэтгэлийн тэнхээтэй, хүн төлөвшүүлэх гол үүрэгтэй.

Багш нэг сургуульд 5 жил ажилладаг.

АУБ- мөнхийн биш, жил бүр багш солигддог.

- Бага дундын залгамж холбоо сайн учир багш солигдоход хүүхдэд ямарч өөрчлөлт гардаггүй.

Багш дараагийн сургуульд очихдоо өөрийн гэсэн арга туршлагатай, очсон сургуульд туршлагаа түгээн дэлгэрүүлж, мөн туршлага хуримтлуулна.

- Эцэг эхэд зөвөлгөө өгөх, хүүхдийн өрөө, сэтгэл зүйч багш ажилладаг. / Манайхаар нийгмийн ажилтан/

Багш, хүүхэд бүрийг удирдах ажилд хамт олон дотор нь хийлгэж сургадаг.

- Багш секц, нэгдэл багийн ахлагчийн ажлыг 1-2 жилийн хугацаатай хийж удирдах ажилд суралцдаг.
- Ангийн даргын ажлыг өдөрт нэг хүүхэд хийдэг.

Ёс зүйн хичээл, бие биетэйгээ харьцах, харьцаа маш чухал эрхэм дээд зүйл

**Мэндчилгээ
Цэвэрлэгээ
Хувцаслалт
Идэвх /үйл ажиллагаа/
Амьд амьтан, байгальтай зөв харьцах,
амьдрах ухаан бие биенээ хүндэтгэх
урлагт сургадаг.**

**Багш хүүхдийн
харилцаа ёс зүйн соёл
хэвшсэн.**

**Хүүхдийг аливаа юманд
хандах зөв хандлагатай
болгох нь хичээлийн
судалгааны үр дүн**

Жигд хувцастай: /Хүүхдийн өмссөн бүх хувцас сургуулиараа ижил/

Сургуульд үйлчилгээний ажилтан гэж байдаггүй

**Бүх багш хүүхэд, эцэг эх өөрсдөө
сургуулиа цэвэрлэдэг**

**00 үйлчлэгч
байхгүй**

**Хүүхэд багаасаа маш эмх цэгцтэй,
цэвэрч сурсан**

Үдийн хоол:

- Сургуульд ажиллаж байгаа бүх хүн ижил хоол иднэ.
- Хүүхдийн хоолны мөнгийг эцэг эх хариуцна.
- Илчлэг, чанартай хоол өгдөг.

Эцэг эхийн үүрэг, оролцоо

- Эцэг эх үүрэг, эрхээ сайн биелүүлдэг.
- Сургуулийн захиргаа, АУ багш эцэг, эхтэй гэрээтэй ажилладаг.
- Хүүхдийг хөгжүүлэх тал дээр хамтарч ажилладаг.
 - Авьяасыг нээдэг
 - Хөгжүүлдэг
 - Сургадаг

Хүнийг хүнтэй харьцуулдаггүй

- Ур чадварын уралдаан гэж тусгайлан явагддаггүй.
- Улсын хэмжээнд судалгаат, сайжруулсан хичээлийн хэлэлцүүллийг явуулж хэвшсэн.

Япон улсын туршлагаас өөрийн сургууль, **“Толгойт Хөгжил дэвшил”** бүсийн сургуулиудад түгээн дэлгэрүүлж байгаа байдал

- ❖ Сургуулийн жилийн ажлын төлөвлөгөөнд багш, хүүхэд, эцэг эхийн зорилго, зорилт саналыг тодорхой тусган ажиллаж байна.
- ❖ Эцэг эхийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх ажлыг үе шаттай, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.
- ❖ Сургуульд суурилсан хичээлийн судалгаа, хичээлийн бэлтгэл судалгаа хийх арга, түүний хэрэгцээ орчин бүрдүүлэх, бидний хичээлийн зорилго арга хэрэгсэл зөв үү? гэдгийг анхааран хэлэлцэж, хэлэлцүүлгийг чанартай өгөөжтэй байлгахад чиглүүлэн ажиллаж байна.
- ❖ **“Толгойт Хөгжил дэвшил”** бүсийн 7 сургуулийн 8 мэргэжлийн багш нарт сургуульд суурилсан хичээлийн судалгааг хэрхэн зохион байгуулах тухай сургалт хийж хэвшиж байна.

- ❖ Бүсийн 7 сургуулийн залуу багш нарт хичээлийн бэлтгэл судалгаа хийх арга зүй, хичээлд ажиглалт хийж хэлэлцүүлэгт оролцох тухай үзүүлэх хичээлийг 10 сард хийсэн.
- ❖ Багш нар хичээлийн судалгааны тайлан бичиж, хичээлийн судалгаанд ач холбогдол өгч хэвшсэн.
- ❖ Багш сургууль дээрээ хөгжих орчныг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна.
- ❖ Багш хамт олон дотроо удирдах ажил хийх боломжийг нээж өгсөн.
- ❖ Жил бүр ЗАН, секц, ОНБ-ын дарга нар солигдож байна.
- ❖ АУБ нар ангидаа хүүхэд бүр удирдах ажил хийх нөхцлийг бүрдүүлэн ажиллаж эхэлсэн.
- ❖ Ангиуд гэрээт үйлчлэгчгүй болсон.

- ❖ Бага ангид хичээл эхлэхийн өмнө **10 минут ном уншиж** хэвшиж байна.
- ❖ Удирдах ажилтан, багш, ажилчид, хүүхэд, эцэг эхийн **харьцааны соёлд** ач холбогдол өгч, сургалт зохион байгуулан өргөн хүрээтэй ажиллаж байна.
- ❖ Мониторингийн судалгаат хичээлд бүсийн 7 сургуулийн 8 мэргэжлийн 86 багш ажиглалт хийн хэлэлцүүлэгт оролцож **“Хэрэв би заасан бол”** гэсэн өнцгөөс санал бодлоо илэрхийлж харилцан туршлага солилцлоо.
- ❖ Бүсийн сургуулиудийн сургалтын менежерүүдийг баг болгон ахлагчаар нь сургуулийн захирал Д. Наранцацралт ажиллан багш нарын заах арга зүйг хөгжүүлэх ажлыг төсөлд тулгуурлан зохион байгуулдаг.

Япон улсад үзэж харсан туршлага, өөрийн сургууль, бүсийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа танилцуулсан болно.

**Авах гээхийн ухаанаар
хандаарай.**